

САНАМЖ

- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ үү.
- Өгсөн зайд цэвэр гаргацтай бичээрэй.

- 1 **143200, 142500, 140520** тоонуудын хувьд өгүүлбэрүүдийн үнэн, худлыг сонгон ✓ тэмдэглээрэй.

№	Өгүүлбэр	үнэн	худал
1	Дээрх тоонуудын “4”-ийн цифр нь мянгатын орныг зааж байна.		
2	Дээрх тоонуудыг арван мянгатаар тоймлоход 140000 гарна.		

- 2 $1\frac{1}{4}$ бутархайг засагдах бутархай хэлбэрт зөв бичсэн хариуг олоорой.


А. $\frac{6}{4}$

Б. $\frac{5}{4}$

В. $\frac{4}{4}$

Г. $\frac{7}{4}$

- 3 Дүрсийн будсан хэсгийг илэрхийлэх аравтын бутархай аль нь вэ?



А. 0.6

Б. 0.4


В. 0.04

Г. 0.06


- 4 1 л багтаамжтай саванд хийсэн усны хэмжээг зурагт үзүүлэв. Усны хэмжээ 200 мл байх савыг сонгоорой.




А.



Б.




В.



Г.

5

ABC гурвалжныг параллель зөөхөд $A_1B_1C_1$ гурвалжин гарав. Гурвалжныг хэдэн нэгжээр, ямар чиглэлд зөөсөн байна вэ?



- А. Баруун гар тийш 2 нэгжээр зөөсөн
- Б. Баруун гар тийш 5 нэгжээр зөөсөн
- В. Зүүн гар тийш 5 нэгжээр зөөсөн
- Г. Зүүн гар тийш 2 нэгжээр зөөсөн

6

Хүснэгтэд таван өдрийн цаг агаарын мэдээг харууллаа.



даваа	мягмар	лхагва	пүрэв	баасан
-8°C	-5°C	0°C	5°C	1°C



Цаг агаарын мэдээг ажиглаад, өгүүлбэрүүдийн үнэн, худлыг сонгон ✓ тэмдэглээрэй.

№	Өгүүлбэр	үнэн	худал
1	Лхагва гарагт хамгийн хүйтэн байна.		
2	Баасан, лхагва гарагууд дахь агаарын температур -1°C -ээс их байна.		

7

Эгч дараах хүнсний ногоонуудыг худалдан авлаа.


өргөст хэмх – $1\frac{4}{8}$ кг, ногоон навч – $\frac{5}{8}$ кг, чинжүү – $1\frac{5}{8}$ кг

А. Худалдан авсан ногоонуудын нийт жин 2 кг болох хоёр өөр ногоог сонгон бичээрэй.

Б. Эгч нийт хэдэн кг ногоо худалдан авсан бэ?

8

75 см урттай , 55 см өргөнтэй хананд тэгш өнцөгт хэлбэртэй зургийг наав.



А. Наасан зургийн талбайн хэмжээг олоорой.

Б. Хананы зураг наагаагүй үлдсэн хэсгийн талбайн хэмжээг олоорой.

9

Оймс үйлдвэрлэдэг компанийн мэдээллийг хүснэгтэд харууллаа.

Бэлэн байгаа оймс	800 хос
Өдөрт үйлдвэрлэх оймс	200 хос
Хүргэлт хийх хугацаа	2 өдөр

Нэгэн дэлгүүр тус үйлдвэрээс 3600 хос оймс захиалжээ. Дэлгүүр захиалсан оймсоо 14 хоногийн дотор хүлээн авах хүсэлтэй байгаа бол үйлдвэр энэ хугацаанд амжиж хүргэж чадах уу?

☐ тийм

☐ үгүй

✚ Хариултад тохирох тооцоолол хийнэ үү.

10

Жимсний дэлгүүрт алим, лийр, гадил, усан үзэм гэсэн 4 төрлийн жимс нийт 80 кг иржээ. Алим болон лийр нийлээд 32.4 кг, харин гадил, усан үзэм, алим 3 нийлээд 54.6 кг байв. Алим хэдэн кг ирсэн бэ?

[illegible]